



**ӨМНӨГОВЬ АЙМАГ  
ГУРВАНТЭС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 01

Урт

Г Ажлын төлөвлөгөө батлах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дахь заалтыг үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны ажлын төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг Хурлын дарга / Б.Дэжид/, Тэргүүлэгчид, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /П.Одончимэг/ нарт үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ДЭЖИД



Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн  
2016 оны 07 сарын 07 тоот тогтоолын хавсралт

ГУРВАНТЭС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
2016 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2016 он.

Урт.

№	Хийгдэх ажлууд	Нэг. Удирдлага зохион байгуулалтын талаар				Хариуцах эзэн			
		1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал				
1.	ИТХурлын үзэл баримтлал, Засаг даргын Үндсэн чиглэл, мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авч хэрэгжилт, үр дүнг нь иргэдэд байнга мэдээлж ажиллах	+	+	+	+	ИТХ-ын дарга, Төлөөлөгчид	Тэргүүлэгчид,		
2.	Багуудын хурал, өдөрлөгийн арга хэмжээнд төлөөлөгчдийг оролцуулж хийсэн ажлын тайланг бичгээр авч үр дүнг тооцох	+	+	+	+	ИТХ-ын дарга, бичгийн дарга	ИТХТ-ийн нарийн бичгийн дарга		
3.	Төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэх, хариуцлагын тогтолцоог сайжруулахад анхаарч чиглэл өгөх, байгууллага, мэргэжилтнүүдийн тайланг хэлэлцэж зөвлөмж өгөх	+	+	+	+	ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид			
4.	ИТХурлаас шийдвэр гаргахад шаардагдах судалгааг шинэчилж, баяжуулах	+	+	+	+	ИТХТ-ийн нарийн бичгийн дарга			
5.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлыг эрчимжүүлж, иргэдэд сурталчлах, сургалт зохион байгуулах	+	+	+	+	ГХУСАЗСЗөвлөл			
6.	Байгаль орчныг хамгаалах чиглэлээр сумын Засаг даргын хийсэн ажлыг Хуралдаан болон Тэргүүлэгчдийн Хурлаар хэлэлцэх					ИТХ-ын тэргүүлэгчид, хурлын хороод			
7.	Сумын Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг аймгийн болон Төрийн дээд шатналд тодорхойлох, байгууллагын дарга, эрхлэгч нэр, багийн Засаг дарга нэрт иргэдийг шатналд тодорхойлоход анхаарах асуудлаар сургалт зохион байгуулах	+	+	+	+	ИТХ-ын дарга, бичгийн дарга	ИТХТ-ийн нарийн бичгийн дарга		
8.	БИНХурлын дарга нарын ажлын хариуцлагыг сайжруулах зорилгоор сургалт зохион байгуулж, гэрээ байгуулж дүгнэн хариуцлага тооцох	+				ИТХТ-ийн нарийн бичгийн дарга			
9.	Сум орон нутгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгжийг сар шинийн баяраар Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж шалгаруулан сумын ИТХурлын нэрэмжит " Хүндэт Өргөмжлөл", мөнгөн шагнал 100000 төгрөгөөр шагнана.	+				ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид			
10	Улаан загалмайн ажлыг эрчимжүүлж, онцгой гишүүдийн тоог нэмэгдүүлэх	+	+	+	+	ИТХ-ын дарга, бичгийн дарга	ИТХТ-ийн нарийн бичгийн дарга		

Хоёр. Нийгмийн бодлогын хүрээнд

1.	Сумын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийг баталж хэрэгжилтэнд үнэлэлт дүгнэлт өгөх				+			ИТХ-ын дарга, Төлөөлөгчид	Тэргүүлэгчид,
2.	Иргэд аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн саналд тулгуурлан орон нутагт шаардлагатай дүрэм, журам боловсруулж батлан мөрдөж хэрэгжилтэнд хяналт тавина			+				ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид, хурлын хороод, Төлөөлөгчид	хурлын хороод, Төлөөлөгчид
3.	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж хамтарч ажиллах			+				ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид, хурлын хороод	хурлын хороод
4.	Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас батлагдсан хөтөлбөр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг сонсож, хэлэлцэн үнэлэлт дүгнэлт өгөх								

Гурав.Сургалт, Сурталчилгааны талаар.

1.	ИТХурлын нээлттэй хаалганы өдөр зохион байгуулах							ИТХ-ын дарга, Төлөөлөгчид, БИНХ-ын дарга нар	Тэргүүлэгчид,
2.	Хурал, Хуралдааны үйл ажиллагаа, Төлөөлөгчдийн ажлын үр дүнгийн талаар тойргийн сонгогчдод мэдээлнэ.			+				ИТХ-ын дарга, Төлөөлөгчид	Тэргүүлэгчид,
3.	Хүүхэд залуучуудыг ахмад үеэ хүндэтгэн дээдэлж, эх орноо хайрлан хамгаалдаг, үндэсний зан заншлаа уламжлан сэргээдэг иргэн болгон хүмүүжүүлэхэд анхаарах			+				ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид, ИТХТ-ийн нарийн бичгийн дарга	ИТХТ-ийн нарийн бичгийн дарга,
4.	Хууль сурталчлах зорилгоор хуулиудын заалтаар анхаарал, санамж зөвлөмж бичиж иргэдэд өргөн сурталчилна.			+				ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид, ИТХТ-ийн нарийн бичгийн дарга, БИНХ-ын дарга	нарийн бичгийн дарга, хурлын хороод
5.	Иргэний танхимыг байнгын үйл ажиллагаатай болгож, иргэдийн санал бодлыг сонсон иргэдийг байнгын мэдээллээр хангаж, иргэдэд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэж холбогдох байгууллагуудад уламжлах			+				ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид, ИТХТ-ийн нарийн бичгийн дарга, хурлын хороод	

Дөрөв. Хяналт шалгалт, сахилга дэг журмын талаар.

1.	Сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бодлого хөтөлбөр, төсөл чиглэл зэрэг баримт бичгүүдийн хэрэгжилтэнд хяналт тавих							ИТХ-ын дарга, Төлөөлөгчид, хурлын хороод	Тэргүүлэгчид,
2.	Хурлын байгууллагаас хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулж, тусгай төлөвлөгөөний дагуу аж ахуйн нэгж байгууллагуудын дунд хяналт шалгалт явуулж, дүнг тэргүүлэгчдийн Хурлаар хэлэлцэж дүгнэлт гарган ажиллана			+				ИТХ-ын дарга, ИТХ-ын Тэргүүлэгчид, төлөөлөгчид, хурлын хороод	Тэргүүлэгчид
3.	Уул уурхайн компаниудын үйл ажиллагаанд хяналт тавьж, хамтарч ажиллах			+				Тэргүүлэгчид	Тэргүүлэгчид, Хяналтын зөвлөлүүд
4.	Орон нутагт эдийн засаг нийгмийг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй сангуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, тайланг ИТХТ-ийн хурлаар хэлэлцэх			+				ИТХ-ын дарга, ИТХТ-ийн нарийн бичгийн дарга	нарийн бичгийн дарга
5.	Орон нутгийн хөгжлийн сангийн хяналтын зөвлөлийг ажиллах боломжоор хангах			+				ИТХ-ын дарга	
6.	Хөрөнгийн хяналтыг тодорхой тооны байгууллага, үйл ажиллагаанд хийж зөрчил дутагдлыг арилган хамтран ажиллах			+					
7.	Сумын Цагдаагийн тасгийн үйл ажиллагаанд удирдлага арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллах			+				ИТХ-ын дарга	

СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД



**ӨМНӨГОВЬ АЙМАГ  
ГУРВАНТЭС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 02

Урт


Г Ажилчдын орон тоо, цалингийн сан Г  
тогтоох тухай.

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь заалтыг үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажилчдын орон тоо, цалингийн санг хавсралт 1, ИТХТэргүүлэгчдэд улиралд нэг удаа олгох урамшуулал, Багийн Иргэдийн Нийтийн Хурлын дарга нарт сар бүр олгох урамшууллыг хавсралт 2 ёсоор тус тус баталсугай.

2.Уг тогтоолд заагдсан ажилчдын Үндсэн цалин, нэмэгдэл урамшууллыг тухай бүр тооцож олгохыг Нягтлан бодогч /Н.Цэнгэлмаа/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ДЭЖИД



Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн  
2016 оны ... тоот тогтоолын нэгдүгээр хавсралт

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын орон тоо, цалингийн сан

№	Албан тушаал	Овог нэр	Цалингийн шатлал	Үндсэн цалин	Ажилласан жил			Нэмэгдлүүд				Дүн
					Угсад	Төрийн байгууллагад	Тухайн албан тушаалд	Онцгой нэмэгдэл /% /	ТАХ-ы /% /	Зэрэг дэв /% /	Ажил хавсарсан ХАСХОМ /	
1	ИТХ-ын дарга	Б.Дэжид	УТ	835276	23	18	3	/30/ 250582				1085858
2	ИТХТ-ийн нарийн бичгийн дарга	П.Одончимэг	ТЗ-7-3	663720	11	11	11		/10/ 66372	/22/ 146018	/10/ 66372	942482

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн  
2016 оны 02 тоот тогтоолын хоёрдугаар хавсралт



ИТХТ-ийн урамшуулал

№	Овог нэр	Урамшил	Тайлбар
1	Ц.Баатар	115200	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 60 хувьтай тэнцэх хэмжээний урамшуулал олгох аймгийн ИТХТ-ийн 2010 оны 94 тоот тогтоолтой. /Улиралд /
2	О.Баттогтох	115200	
3	Ц.Дэлгэрмаа	115200	
4	А.Занахүү	115200	
5	А.Нинжбадгир	115200	
6	Б.Эрдэнэбаян	115200	
	Дүн	691200	

Багийн ИНХ-ын дарга нарын урамшуулал

№	БИНХ-ын дарга	Олгох урамшуулал	Тайлбар
1	О.Баярмаа	166082	ЗЗНДНТУТХ-ийн 38,6 дахь заалтад заагдсан
2	Д.Болормаа	166082	
3	А.Нямцоо	166082	
4	Н.Чинбат	166082	
	Дүн	664328	



**ӨМНӨГОВЬ АЙМАГ  
ГУРВАНТЭС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 03

Урт

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын албан байгууллагуудын шилэн дансны мэдээлэлд хяналт тавьж ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.


Ажлын хэсгийн дарга О.Баттогтох /Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгч/

Гишүүдэд: А.Занахүү /Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгч/

Ц.Баатар /Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгч/

2. Байгууллагуудын шилэн дансны мэдээлэлд хяналт тавьж тайланг сар бүрийн 10-ны дотор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албанд бичгээр ирүүлж ажиллахыг ажлын хэсгийн дарга /О.Баттогтох/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ДЭЖИД



ӨМНӨГОВЬ АЙМАГ  
ГУРВАНТЭС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 04

Урт

Зөвлөл шинэчлэн батлах тухай

Монгол улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16-р зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

Үүнд: Зөвлөлийн дарга- Б.Дэжид /Хурлын дарга /

Орлогч даргад - Г.Гангамаа /Сумын Засаг дарга/

Гишүүдэд: З.Оюунцэцэг /Эрүүл мэндийн төвийн эрхлэгч/

Б.Энхжаргал /ЕБСургуулийн захирал/

М.Мөнхбархас /ЗДТГ-ын нийгмийн ажилтан/

О.Батмөнх /Гоёт багийн Засаг дарга/

Д.Айлтгүй /Баясах багийн Засаг дарга/

Н.Галаахүү /Тост багийн Засаг дарга/

Л.Пүрэвдорж /Урт багийн Засаг дарга/

Г.Лхагва /Иргэний төлөөлөл/

Нарийн бичгийн даргад- Л.Далайжаргал /Сумын хэсгийн төлөөлөгч/

2. Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлыг тогтмолжуулж, зөвлөлийн ажиллах журмыг мөрдөж ажиллахыг Зөвлөлийн дарга /Б.Дэжид/-д даалгасугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 01-р сарын 06-ны өдрийн № 03 тоот тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА Б.ДЭЖИД





ӨМНӨГОВЬ АЙМАГ  
ГУРВАНТЭС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 05

Урт

Зөвлөл шинэчлэн батлах тухай

Монгол улсын Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сум хөгжүүлэх санг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Зөвлөлийн дарга: - Г.Гангамаа /сумын Засаг дарга/

Гишүүдэд: - Б.Балмаа /Мал эмнэлэг үржлийн тасгийн дарга/

- Ж.Ганбаатар-/ Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн/
- З.Дэчин- Иргэний төлөөлөл
- Б.Өлзий-Орших- Иргэний төлөөлөл
- Б.Нарантуяа- Иргэний төлөөлөл


Нарийн бичгийн дарга Ц.Энхбаяр- Хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Журмын дагуу жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, орон нутагт хэрэгцээтэй, шаардлага хангасан төсөлд зээл олгож, сум хөгжүүлэх сангийн тайланг хагас бүтэн жилээр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, аймгийн Хөдөлмөрийн хэлтэст тайлагнаж ажиллахыг зөвлөлийн дарга /Г.Гангамаа/-д үүрэг болгосугай.

3. Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн хөрөнгийг гэрээний дагуу сангийн дансанд төвлөрүүлж жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх төслийг санхүүжүүлэхийг зөвлөлд даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 08 тоот тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ДЭЖИД



ӨМНӨГОВЬ АЙМАГ  
ГУРВАНТЭС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 06

Урт

Г Өвөлжөө хаваржааны газар эзэмшүүлэх Г  
журам батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ийн “з” дахь заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдын Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Сумын бэлчээр, усыг зохистой ашиглаж, хамгаалах зорилгоор өвөлжөө хаваржааны газар эзэмшүүлэх журмыг хавсралтаар баталсугай.
2. Журмыг хэрэгжүүлж, хэрэгжилтийг иргэдийн төлөөлөгчдийн хуралд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга /Г.Гангамаа /-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ДЭЖИД

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн  
2016 оны 06 тоот тогтоолын хавсралт



## ГУРВАНТЭС СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ӨВӨЛЖӨӨ, ХАВАРЖААНЫ ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Гурвантэс сумын нутаг дэвсгэрт буй өвөлжөө, хаваржааны газрыг эзэмшихтэй холбогдуулан үүсэх харилцааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.
- 1.2 Энэ журам нь "Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай ууль", "Газрын тухай хууль", "Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2008 оны 83 дугаар тушаал", "Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 131 тоот тушаал"-ыг тус тус үндэс болгосон.

### Хоёр. Бэлчээр ашиглахтай холбогдуулан шинээр өвөлжөөг эзэмшүүлэхэд тавигдах шаардлага

- 2.1 Нэг өвөлжөөтэй малчин өрхөд дахин өвөлжөө, хаваржааг эзэмшүүлэхгүй.
- 2.2 Шинэ өрх үүсгэсэн малчин өрхөд нэг өвөлжөө эзэмшүүлнэ.
- 2.3 Өвөлжөө, хаваржааны зориулалттай газрыг 30 хүртэл жилийн хугацаатай эзэмшүүлнэ.
- 2.4 Шинээр эзэмших өвөлжөөны газар нь бусдын эзэмшилд байгаа өвөлжөөний газраас 5 км буюу түүнээс дээш зайтай байна. Өөрөөр хэлбэл өвөлжөө хоорондын зай 5 км-с доошгүй байна гэж ойлгоно.
- 2.5 Тухайн газар нь бусдын эзэмшилд байгаа газартай давхцаагүй байх.
- 2.6 Газар эзэмших иргэн нь зөвхөн тус сумын иргэний харъяалалтай байна.
- 2.7 Газар эзэмших эрхийг өрхийн нэг гишүүнд үүсгэнэ.
- 2.8 Хороо бууцгүй газарт шинээр өвөлжөө олгохгүй.
- 2.9 Өвөлжөөний зориулалт бүхий газрыг малчин өрхөд олгоно.
- 2.10 Шинээр олгож буй өвөлжөөг газар зүйн байршилыг тодорхойлуулж байх.

### Гурав. Бэлчээр ашиглахтай холбогдуулан газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэх

- 3.1 Газар эзэмшигч нас барсан тохиолдолд тухайн газар эзэмших эрхийг хамтран эзэмшиж буй малчин өрхөд шилжүүлэх, хамтран эзэмшигчгүйгээр эзэмшиж байсан тохиолдолд багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцэж шилжүүлэн эзэмшүүлэх.
- 3.2 Газар эзэмшигч шилжин харъяалалаа солих тохиолдолд тухайн сумын харъяалалд байгаа хамтран эзэмшигч малчин өрхийн тэргүүлэгчид шилжүүлэх, хамтран эзэмшигчгүй тохиолдолд газрыг багийн Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж шилжүүлэн эзэмшүүлэх, чөлөөлүүлэх.
- 3.3 Газар эзэмших эрхийг зөвхөн тус сумын харъяалалтай иргэнд шилжүүлнэ.
- 3.4 Өвөлжөөний зориулалттай газар эзэмшиж буй малчин өрхөд нэмж эзэмших эрх шилжүүлэхгүй.

### Дөрөв. Бэлчээр ашиглагчийн эрх, үүрэг

- 4.1 Өвөлжөөний зориулалттай газрыг худалдан шилжүүлэх буюу худалдан авч болохгүй.
- 4.2 Газар эзэмшигч нь бэлчээр ашиглахтай холбогдсон маргааныг холбогдох албан тушаалтанд бичгээр өргөдлөө гаргаж өгч шийдвэрлүүлнэ.

**Тав. Бэлчээр ашиглахтай холбогдсон сум, багийн Засаг даргын бүрэн эрх**

- 5.1 Иргэдийн хүсэлтийг хүлээн авч, Багийн Иргэдийн Нийтийн хурлаар буюу багийн иргэдийн нийтийн хурлын тэргүүлэгчдээр хэлэлцүүлж шийдвэрлэнэ.
- 5.2 Бэлчээр ус зохистой ашиглах арга хэмжээг зохион байгуулах.
- 5.3 Бэлчээр ус зохистой ашиглах талаар багийн Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж сумын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд тусгаж мөрдөн ажиллуулах. Үл тохиролцсон тохиолдолд сум болон багийн Засаг дарга шийдвэрлэнэ.
- 5.4 Бэлчээр ашиглахтай холбогдсон аливаа маргааныг журмын дагуу шийдвэрлэнэ.

**Зургаа. Газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох**

- 6.1 Газар эзэмших эрхийг өөрийн нэр дээр шилжүүлж аваагүй.
- 6.2 Газар эзэмших эрхийн гэрчилгээ эзэмшигч нь газрын төлбөрөө цаг хугацаанд нь бүрэн төлөөгүй.
- 6.3 Эзэмшигч өөрийн эзэмшлийн газартаа гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газрыг 2 жил ашиглаагүй.
- 6.4 Малаа маллахгүй байгаа малгүй болон мал бүхий өрхийн эзэмшилд байгаа өвөлжөө хаваржааны газар эзэмших эрхийг багийн Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэнэ.

**Долоо. Бэлчээртэй холбогдсон маргааныг шийдвэрлэх**

- 7.1 Бэлчээр ашиглах асуудлаар гарсан аливаа маргааныг багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж зохицуулна. Үл тохиролцсон тохиолдолд сум болон багийн Засаг дарга шийдвэрлэнэ.

**Найм. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

- 8.1 Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр газар ашигласан буюу хороо бууц барьж байгуулсан иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, хохирлыг нөхөн төлүүлнэ. \Газрын тухай хуулийн 63.1.11\
- 8.2 Журам зөрчсөн гэм буруутай иргэд Захиргааны хариуцлагын тухай хуулийн 32 дугаар зүйлийг үндэслэн захиргааны хариуцлага ноогдуулах ба эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Байгаль Орчны хяналтын улсын байцаагч Газрын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.8 дахь хэсэгт заасны дагуу иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1-4 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төгрөгөөр торгож хохирлыг нөхөн төлүүлнэ.



**ӨМНӨГОВЬ АЙМАГ  
ГУРВАНТЭС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 07

Урт

Г Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот Г  
үйлдвэрийн газар байгуулж, дүрмийг батлах тухай


Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ийн “ж” дахь заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Тус суманд “Шугшаа-Уул” нэртэй орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг байгуулсугай.

2. “Шугшаа-Уул” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийг хавсралтаар баталсугай.

3. “Шугшаа-Уул” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын удирдлагыг 2016 оны 01 сарын 29-ны дотор томилж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга /Г. Ангамаа/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б. ДЭЖИД

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн  
2016 оны 7-р тоот тогтоолын хавсралт



**“ШУГШАА УУЛ” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ  
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДҮРЭМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. “Шугшаа уул” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар /ОНӨААТҮГ/ нь бие даасан тайлан тэнцэлтэй, банкинд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хүлээх хуулийн этгээд,
- 1.2. “Шугшаа уул” ОНӨААТҮГ /Цаашид “Үйлдвэрийн газар” гэх/ нь үйл ажиллагаандаа Монгол улсын Үндсэн хууль, Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хот суурины усан хангамж, татуургын ашиглалтын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиуд болон монгол улсын бусад холбогдох хууль тогтоомж, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын болон Тэргүүлэгчдийн тогтоол, Засаг даргын захирамж, үйл ажиллагааны хөтөлбөр болон энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.
- 1.3. Үйлдвэрийн газрын өмчлөгч нь сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал байх бөгөөд төлөөлөл хэрэгжүүлэгч нь сумын Засаг дарга байна.

**Хоёр. Газрын оноосон нэр, оршин байгаа газар**

2.1. Аж ахуйн нэгжийн оноосон нэр: “ШУГШАА УУЛ” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

А. Бүрэн нэр: “ШУГШАА УУЛ” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

Б. Товчилсон нэр: “ШУГШАА УУЛ” ОНӨААТҮГ

2.2. Аж ахуйн нэгжийн оршин байгаа хаяг: Өмнөговь аймгийн Гурвантэс сум Урт баг

**Гурав. Үйл ажиллагааны чиглэл**

3.1. “Шугшаа уул” ОНӨААТҮГ нь үйл ажиллагаагаа дараах чиглэлээр явуулна.

3.1.1 Хог цуглуулах, тээвэрлэх

3.1.2 Цэвэр бохир усны түгээлт, холболт, төв шугамын гэмтэл, бөглөрөл, айл өрхүүдийн дуудлагын үйлчилгээг гүйцэтгэнэ.

3.1.3 Сумын төвийн авто зам, явган замын арчилгаа, гэрэлтүүлэг шинээр хийх, засварлах

- 3.1.4 Сум орон нутагт төсөл, хөтөлбөр болон орон нутгийн санхүүжилтээр хийгдсэн нийтийн эзэмшлийн талбайн хадгалалт хамгаалалт, арчилгаа
- 3.1.5 Зочид буудал, зоогийн газар, түрээсийн үйлчилгээ
- 3.1.6 Халуун ус
- 3.1.7 Гадаад, дотоод худалдаа
- 3.1.8 Барилга, засвар үйлчилгээ, ногоон байгууламж, байгаль орчны нөхөн сэргээлт
- 3.1.9 Хүнсний үйлдвэрлэл эрхлэх
- 3.1.10 Асфальт бетон, хайрга, сайжруулсан хөрс үйлдвэрлэл, хар шорооны карьерийн үйл ажиллагаа
- 3.1.11 Нийтийн ахуйн үйлчилгээний ашиглалт, арчлалт, хамгаалалт
- 3.2. Үйлдвэрийн газар нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.

#### **Дөрөв . Үйлдвэрийн газрын үндсэн эрх**

- 4.1. Үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирлыг Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Засаг дарга томилон үйл ажиллагааг удирдуулна. Энэ нөхцөлд хуулийн хүчин төгөлдөр гэрээ байгуулан түүний эрх хэмжээг тогтоож өгнө.
- 4.2. Үйлдвэрийн газрын дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг гүйцэтгэх захирал саналаа боловсруулж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдэд оруулж шийдвэрлүүлнэ.
- 4.3. Үйлдвэрийн газрын хэлбэрийг өөрчлөх, өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид шийдвэрлэнэ.
- 4.4. Үйлдвэрийн газар нь өөртөө барааны тэмдэг болон бэлгэдэл /эмблем/ албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тэмдэг /тамга/ хэрэглэнэ.
- 4.5. Үйлдвэрийн газар нь өөрийн үйл ажиллагаагаа бие даасан байдлаар Монгол Улсын хуулийн хүрээнд эрхлэн явуулна.
- 4.6. Үйлдвэрийн газар өөрийн үйл ажиллагаагаа өргөтгөх, үйлчлүүлэгчид болон зах зээлдээ ойртох гэх мэт зорилгоор улс дотроо болон гадаадад салбар төлөөлөгчийн газар ажиллуулж болно.
- 4.7. Үйлдвэрийн газрын үндсэн ба туслах үйлдвэрлэл, үйлчилгээний ажлыг хэвийн явуулах зорилгоор мэргэжил чадвар сайтай, дадлага туршлагатай хүмүүсийг хөдөлмөрийн гэрээгээр авч ажиллуулах, тэдний ажиллах нөхцөл, цалин хөлс, урамшууллын хэмжээг тогтооно.
- 4.8. Үйлдвэрийн газар нь төрийн болон бусад аж ахуйн нэгж, байгууллага, түүнчлэн олон улсын холбогдох байгууллагад элсэн, ашиг сонирхлоо хэрэгжүүлэхэд төлөөлүүлэх, хамтран ажиллах зэргээр зохицуулалт хийнэ.
- 4.9. Үйлдвэрийн газар нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл цуглуулах, мөн тийм мэдээллийг үйлчлүүлэгч, сонирхогчдод хүргэнэ.
- 4.10. Үйлдвэрийн газар өөрийн үйл ажиллагаатай холбоотой зарим зүйлийг хуулийн дагуу нууцлана.
- 4.11. Үйлдвэрийн газрын тайлан тэнцэл, аудиторын тайлан, гүйцэтгэх захирлын тайланг Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Засаг дарга тус тус хянаж батална.

#### **Тав. Үйлдвэрийн газрын үндсэн үүрэг.**

- 5.1. Үйлдвэрийн газар нь энэхүү дүрмийн 3.1.1-ээс 3.1.11-д заасан үйл ажиллагааг Монгол улсын хуульд заасны дагуу эрхлэх үүрэгтэй.
- 5.2. Үйлдвэрийн газар нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хуулийн дагуу нягтлан бодохын болон анхан шатны, дэлгэрэнгүй бүртгэлийг хөтлөн санхүүгийн тайлан тэнцэл гарган баталгаажуулна.

5.3. Үйлдвэрийн газар нь Монгол улсын Албан татварын хуулиудын заалтыг хатуу мөрдөн татвараа өөрөө тодорхойлж, сайн дураар төлнө.

5.4. Монгол Улсын хууль, тогтоомжийн дагуу шаардлагатай мэдээ, мэдээллийг цаг тухай бүр эрх бүхий байгууллагуудад гаргаж өгнө.

#### **Зургаа. Үйлдвэрийн газрын үндсэн хариуцлага**

6.1. Үйлдвэрийн газар нь зөвхөн өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээнэ.

6.2. Монгол улсын хуульд заасан бусад хариуцлагыг хүлээнэ.

6.3. Үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч нар нь гэрээнд заагдсан хугацаанд эрх бүхий албан тушаалтан байх бөгөөд тэдгээр нь өөрийн хууль бус үйл ажиллагаанаас учирсан хохирлыг хариуцна.

#### **Долоо. Үйлдвэрийн газрын хөрөнгө**

7.1 Үйлдвэрийн газар өөрийн хөрөнгө буюу дүрмийн сан нь **1000000** төгрөгийн хөрөнгөтэй байна.

7.2 Үйлдвэрийн газар нь өөрийн хуримтлагдсан ашгийн хэмжээгээр дүрмийн сангаа нэмэгдүүлж болно.

7.3 Шаардлагатай нөхцөлд дүрмийн санд шинээр хөрөнгө оруулна.

7.4 Үйл ажиллагааны зарим чиглэлээр охин компани байгуулан дүрмийн сангаа тэр хэмжээгээр хорогдуулж болно.

#### **Найм. Үйлдвэрийн газрын удирдлага, түүний эрх хэмжээ**

8.1. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Засаг дарга нь гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний үзүүлэлтийг жил бүр шинэчлэн батална.

8.2. Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны эрх үүрэг хариуцлагын хэмжээ хязгаар хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс урамшуулал зэргийг хуулийн хүчин төгөлдөр гэрээгээр баталгаажуулна.

#### **Ес. Үйлдвэрийн газрын санхүүгийн тайлан, хяналт шалгалт**

9.1. Үйлдвэрийн газар нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хуулийн дагуу баталгаажуулан үүний үндсэн дээр татварын багц хуулийн заалтад нийцүүлэн тогтоосон хугацаанд нь татварын тайлан гаргаж тооцоо хийнэ.

9.2. Санхүүгийн тайланд дараах хэсгүүдийг заавал оруулна.

9.2.1. Баланс

9.2.2. Орлого үр дүнгийн тайлан

9.2.3. Мөнгөн гүйлгээний тайлан

9.2.4. Хуримтлагдсан ашгийн тайлан

9.2.5. Тайлангийн тайлбар, тодруулга, илтгэх хуудас

9.3. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг захирал хариуцна. Үйлдвэрийн газрын орон тоонд хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ерөнхий нягтлан бодогч энэхүү хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.

9.4. Санхүү аж ахуйн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцэл, татварын тооцооллын үнэн магадад хөндлөнгийн байгууллагаар шалгалт хийлгэж, ажил сайжруулах туслалцаа авч байна.

9.5. Хяналт шалгалт, лавлагаа, түүх архивын зорилгоор дараах баримт бичгүүдийг хуульд заасан хугацаагаар хадгална.

9.5.1. Үйлдвэрийн газрын дүрэм, түүнд орсон өөрчлөлтүүд

9.5.2. Үйлдвэрийн газрын улсын бүртгэлийн гэрчилгээ

9.5.3. Үйлдвэрийн газрын дотоод бичиг материалууд

9.5.4. Үйлдвэрийн газрын салбар болон төлөөлөгчийн газрын дүрэм, гэрээнүүд

9.5.5. Нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон гүйцэтгэх захирлын тушаал, шийдвэр, хурал зөвлөлгөөний тэмдэглэл

9.5.6. Санхүү аж ахуйн үйл ажиллагааны анхан шатны болон дэлгэрэнгүй бүртгэл, ня-бо бүртгэлийн баримт бичиг, материалууд.

9.5.7. Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцэл, түүнтэй холбогдох баримт материалууд.

**Арав. Үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулах татан буулгах, өр төлбөрийг барагдуулах.**

10.1. Үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулах тухай ойлголтод үйлдвэрийн газрыг хуваах бусад компанитай нийлэх, нэгдэх, тусгаарлах, өөрчлөх асуудлууд хамаарагдана.

10.2. Үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулах асуудлыг Компанийн тухай хуулийн 18-24 дүгээр зүйлийн заалтуудыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэнэ.

10.3. Үйлдвэрийн газар дараах үндэслэлээр татан буугдана.

10.3.1. Улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс хойш нэг жилийн хугацаанд дүрэмд заагдсан үйл ажиллагааны чиглэл болох үйлдвэрлэл ажил үйлчилгээ эсвэл түүнтэй холбогдсон бэлтгэл ажлаа хийгээгүй, үйл ажиллагаагаа эхэлсэн боловч дараалсан 12 сараас дээш хугацаагаар тасалдсан тохиолдолд.

10.3.2. Төлбөрийн чадваргүй болж, шүүхийн шийдвэрээр дампуурсан

10.3.3. Хуульд заагдсан бусад үндэслэлүүдээр.

10.4. Үйлдвэрийн газрыг татан буулгах шийдвэр гаргасан байгууллагаас татан буулгах комиссыг томилон ажиллуулна.

10.5. Татан буулгах комисс томилсноор тухайн үйлдвэрийн газрын эрх дуусгавар болж, татан буулгах комисст шилжинэ.

10.6. Татан буулгах комисс нь Компанийн тухай хуулийн 26-29 дүгээр зүйлд заасны дагуу ажиллан, эцэст нь улсын бүртгэлээс компанийг хасуулж ажлаа дуусгавар болгоно.

10.7. Татан буулгах комисс үүргээ гүйцэтгэх үедээ өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас тухайн байгууллагад ямар нэг хохирол учруулсан бол уул хохирлыг хуульд заасан журмын дагуу хариуцна.

**Арван нэг. Дүрэм хүчин төгөлдөр болох**

11.1. Энэхүү дүрмийг монгол хэлээр 4% үйлдэж, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд нэг хувийг, улсын бүртгэлийн хэлтэст нэг хувийг, аймгийн өмчийн албанд нэг хувийг, үйлдвэрийн газар өөрөө нэг хувийг хадгална.

11.2. Энэхүү дүрэм нь иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоол батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.